



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/10

Хэрлэн сум

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын
спортын ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагч, ажиллагсдын дунд эерэг уур амьсгал бүрдүүлж, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх болон хамт олны дунд спортын тэмцээн зохион байгуулах зорилгоор спортын ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Д.Баярхүү

Хөгжлийн бодлого, төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын хэлтсийн
даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Н.Үнэнбат

Санхүү, төрийн сангийн хэлтсийн
дарга

Г.Тэмүүжин

Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн Нутгийн захиргааны
байгууллагын бодлого тогтоол
шийдвэрийн хэрэгжилт хариуцсан
мэргэжилтэн

Г.Пүрэвбаатар

Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн
ам зүйн нийгмийн хамгаалал,
хөдөлмөр эрхлэлт, гэр бүл,
хүүхэд залуучуудын бодлого
хариуцсан мэргэжилтэн

Б.Энх-Уянга

Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн үйлчилгээний стандарт
хариуцсан мэргэжилтэн

2. Спортын ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр гарган ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Баярхүү)-д даалгасугай.

2.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн А/85 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



А.ЖАРГАЛСАЙХАН